

ИМПОРТЫН ГААЛИЙН ТАРИФЫГ ОНОВЧТОЙ ТОГТООХ АРГАЗҮЙ

Н.Батнасан*, Г.Мөнхбаясгалан**

Хураангуй: Импортын тариф нь олон улсын худалдааны зохицуулалтын чухал арга хэрэгсэл юм. Энэхүү судалгаанд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд жижиг нээлттэй эдийн засаг бүхий улс оронд гаалийн тарифийг оновчтой тогтоох асуудлыг авч үзсэн. Энэхүү судалгаа нь хоёр үндсэн зорилготой. Нэгд, гаалийн тарифыг оновчтой тогтоох аргазүйн үндэслэлийг тайлбарлана, хоёрт, төрөл бүрийн барааны тарифын харилцан хамаарлыг харуулах юм.

Түлхүүр үгс: импорт, гаалийн тариф, үнийн мэдрэмж, сүү болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Abstract: An import tariff is the important tool of international trade regulation. This paper examines the optimal tariff rate and structure in a small open economy with the focus to support domestic dairy industry. This paper has two main aims. First, we will explain methodological foundation of optimal tariff rate. Second, we will show tariff interlinkage between the goods.

Key words: Import, customs tariff, price elasticity, dairy industry,

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) batnasan_n@hotmail.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) gbayas0118@gmail.com

Гаалийн оновчтой тарифын түвшинг тооцох үндэслэл

Гаалийн тариф бол олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гадаад худалдааг зохицуулах зохицуулалтын уламжлалт арга хэрэгсэл юм. Гаалийн тариф тогтоох замаар гадаадаас импортлосон хямд үнэтэй барааг дотоодод худалдаалах үнийг өсгөх боломжтой. Ингэж өсгөснөөр улс орнууд дотоодын үйлдвэрлэлээ гадаадын өрсөлдөөнөөс хамгаалах боломжтой болдог. Түүхэн хөгжлийн явцад улс орнууд гаалийн тарифыг импортоо бууруулах замаар төлбөрийн тэнцлээ сайжруулах, дотоодын зах зээлд эрэлт нийлүүлэлтийн оновчтой харьцааг тогтоох, тарифын бус зохицуулалтын хүрээг зөв тодорхойлох, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх гэх мэт олон зориулалтаар ашиглаж ирсэн байна.

Худалдаа, тарифын ерөнхий хэлэлцээр (ХТЕХ)-ийн 8 үе шатны хэлэлцээрийн дараа худалдааг либеральчлах бодлогын хүрээнд дэлхийн улс орнууд гаалийн тарифыг өмнөх үеийн түвшингээс үлэмж хэмжээгээр бууруулсан. Эдүгээ гаалийн тариф нь урьд өмнөх үеийнх шиг гадаад худалдааг зохицуулах хүчтэй арга хэрэгсэл байхаа больсон.

Өнөөгийн дэлхий ертөнцөд гаалийн тарифаа өөрсдөө дур мэдэн тогтоож буй улс орнууд маш цөөхөн юм. Дэлхийн ихэнх улс орнууд ДХБ-д гишүүнээр элсч, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг амлалтынхаа хүрээнд гаалийн тарифаа тогтоож байна. Эдүгээ НҮБ-д бүртгэлтэй 209 улс орноос 164 нь ДХБ-ын байгууллагын эгнээнд элсээд байна. Хамгийн сүүлд хийсэн тооцоогоор ДХБ-ын гишүүн орнуудад дэлхийн нийт худалдааны 96.4%, дэлхийн нийлбэр ДНБ-ий 96.7% тус тус ногдож байгаа юм.³

ДХБ-д шинээр гишүүнээр элсэх улс орнууд бусад гишүүн улс орнуудтай хэлэлцээрийн ширээнд сууж, гишүүнээр элссэнийхээ дараа бусад гишүүн орнуудаас импортлох бараанаас авах гаалийн татварын дээд хэмжээний талаар үүрэг амлалт авдаг. Бусад гишүүн орнуудынхаа өмнө хүлээсэн энэхүү үүрэг амлалтыг буултын жагсаалт гэж нэрлэдэг бөгөөд импортлогч гишүүн улс орон гаалийн татварын дээд хэмжээний талаарх амлалтаасаа доогуур түвшинд гаалийн татвараа тогтоож мөрдөх үүрэгтэй.

Монгол улс ДХБ-д 1997 онд гишүүнээр элсэн орсон бөгөөд архи, тамхи гэх мэт цөөн нэрийн бараанаас бусад импортын барааны хувьд импортын гаалийн татварыг 20%-иас хэтрүүлэхгүй байх үүрэг амлалт хүлээсэн.

Сүүлийн үед улс төрчид, зарим эдийн засагчид, эрдэмтдийн зүгээс гаалийн өндөр татвар тогтоож, татаас өгөх замаар дотоодын үйлдвэрлэлээ импортын өрсөлдөөнөөс хамгаалан хөгжүүлэх талаар ярьж, хэрэгжүүлж эхэлсэн нь бодит

³ "Accession in perspective". World Trade Organization. Retrieved 22 December 2013.

байдалтай нийцэхгүй зүйл юм. Учир нь бид дангаараа дур мэдэн гаалийн өндөр тариф тогтоосноороо бусад гишүүн орнуудын зүгээс худалдааны хориг, хязгаарлалтад орох томоохон эрсдэлтэй учирч болзошгүй.

Хэдий тийм боловч бид олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг амлалтаа зөрчихгүйгээр, импортын бараа бүтээгдэхүүнд гаалийн ялгавартай тариф тогтоох замаар үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зарим боломжууд байгааг энд цохон тэмдэглэхийг хүсч байна.

Гаалийн тариф татварын түвшин нь хэн нэгний хүсэл зоригор шийдвэрлэдэг зүйл биш бөгөөд шинжлэх ухааны тодорхой арга, аргачлалд тулгуурлан оновчтой түвшинд тогтоогдох ёстой. Манай гаалийн практикаас үзэхэд, гаалийн татварыг оновчтой хэмжээнд тогтоох аргачлалыг өнөөдрийг хүртэл боловсруулж чадаагүй байгаа бөгөөд онол практикийн шинжтэй энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор 10 орчим жилийн өмнө боловсруулсан аргачлалдаа тулгуурлан энэхүү өгүүллийг бичиж байна.

Гаалийн тарифыг бүх төрлийн бараанд тогтоох боломжтой боловч онолын хувьд зөвхөн үнийн мэдрэмжтэй барааны импорт гаалийн тарифыг нэмэгдүүлснээр буурна. Эндээс импортын барааны үнийн мэдрэмжийг хэрхэн яаж тооцох вэ, үнийн мэдрэмжийг ашиглан үндэсний үйлдвэрлэлийг хамгаалахуйц гаалийн тарифыг хэрхэн тооцох ёстой вэ гэсэн дараагийн асуултауд логикийн хувьд гарна.

Ханамжийг максимумчлах

Хэрэглэгч хэрэгцээгээ импортын болон дотоодын үйлдвэрлэлийн гэсэн хоёр төрлийн бараагаар хангадаг гэж үзье. Импортын барааны тоо хэмжээг Q_m , дотоодын үйлдвэрлэлийн барааны тоо хэмжээг Q_d гэж тэмдэглэе.

Уг барааны тогтмол эрэлтийн мэдрэмж бүхий ханамжийн функцтэй байсан гэж үзээд ханамжийн функцыг бичвэл:

$$U = [\beta Q_d^\alpha + (1 - \beta)Q_m^\alpha]^{-\frac{1}{\alpha}} \text{ байна.} \quad [1]$$

Энд β нь нийт хэрэглээнд дотоодын барааны эзлэх хувийн жинг, $1-\beta$ нь импортын барааны эзлэх хувийн жинг илэрхийлнэ. α нь ханамжийн функцийн параметр. Үнийн мэдрэмжийг σ гэвэл

$$\sigma = \frac{1}{\alpha-1} \text{ байна.} \quad [2]$$

Хэрэглэгч импортын болон дотоодын үйлдвэрийн гэсэн хоёрхон төрлийн бараанд орлогоо зарцуулдаг гэж үзээд төсвийн хязгаарлалтыг бичвэл:

$$I = P_d Q_d + P_m Q_m \quad [3]$$

Ханамжийг максимумчлахын тулд бид Лагранжийн функцыг бичнэ.

$$L = [\beta Q_d^\alpha + (1 - \beta) Q_m^\alpha]^{-\frac{1}{\alpha}} - \lambda(I - P_d Q_d - P_m Q_m) \quad [4]$$

Лагранжийн функцээс нэгдүгээр эрэмбийн уламжлал авч ханамжийн функц максимум утгаа авах тоо хэмжээ, үнийг тогтооно. Лагранжийн функцээс Q_d -ээр авсан нэгдүгээр эрэмбийн уламжлал нь:

$$L'_{Q_d} = -1/\alpha \alpha \beta Q_d [\beta Q_d^\alpha + (1 - \beta) Q_m^\alpha]^{-\frac{1}{\alpha}-1} - \lambda P_d \quad [5]$$

Харин Q_m -ээр авсан нэгдүгээр эрэмбийн уламжлал нь:

$$L'_{Q_m} = -1/\alpha \alpha (1 - \beta) Q_m [\beta Q_d^\alpha + (1 - \beta) Q_m^\alpha]^{-\frac{1}{\alpha}-1} - \lambda P_m \quad [6] \text{ байна.}$$

Мөн функц [4] -ээс λ -аар нэгдүгээр эрэмбийн уламжлал авбал:

$$I = P_d Q_d + P_m Q_m \quad [7]$$

Ханамжийг максимум хэмжээнд байлгах үнийн хэмжээ болох P_d болон P_m -ийн утгуудыг олохын тулд Лагранжийн функцээс авсан нэгдүгээр эрэмбийн уламжлалыг тэгтэй тэнцүүлнэ. Эндээс ханамжийг максимум хэмжээнд байлгах дотоодын үнийг бичвэл:

$$P_d = \frac{-1/\alpha \alpha \beta Q_d^{\alpha-1} [\beta Q_d^\alpha + (1 - \beta) Q_m^\alpha]^{-\frac{1}{\alpha}-1}}{\lambda} \quad [8] \text{ болно.}$$

Харин ханамжийг максимум хэмжээнд байлгах импортын үнэ нь:

$$P_m = \frac{-1/\alpha \alpha (1 - \beta) Q_m^{\alpha-1} [\beta Q_d^\alpha + (1 - \beta) Q_m^\alpha]^{-\frac{1}{\alpha}-1}}{\lambda} \quad [9] \text{ байна.}$$

Эндээс ханамжийг максимум байлгах импортын болон дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний тоон харьцааг олбол:

$$\frac{Q_d}{Q_m} = \left(\frac{\beta}{1 - \beta}\right)^{\frac{1}{\alpha-1}} \left(\frac{P_d}{P_m}\right)^{\frac{1}{\alpha-1}} \quad [10] \text{ байна.}$$

Эндээс $\sigma = \frac{1}{\alpha-1}$ [11] гэсэн орлуулгыг хийвэл дээрх харьцаа нь гэсэн хэлбэрт шилжинэ.

$$\frac{Q_d}{Q_m} = \left(\frac{\beta}{1 - \beta}\right)^\sigma \left(\frac{P_d}{P_m}\right)^\sigma \quad [12] \text{ болно.}$$

$$\varepsilon = \text{Log} \left(\frac{\beta}{1-\beta} \right)^\sigma \quad [13] \text{ байна гэж}$$

үзээд томъёо 12-ыг хоёр талаар нь логарифмчилбал:

$$\text{Log} \left(\frac{Q_d}{Q_m} \right) = \varepsilon + \sigma \text{Log} \left(\frac{P_d}{P_m} \right) + u_t \quad \text{болно.} \quad [14]$$

14-р тэгшитгэлээс харахад дотоодын зах зээлд худалдаалдаг дотоодын үйлдвэрийн болон импортын барааны тоо хэмжээний харьцаа нь тэдгээрийг дотоодын зах зээлд худалдаалж буй үнийн харьцаанаас шууд хамааралтай бөгөөд үнийн харьцааны өмнөх параметр нь дотоодын болон импортын барааны харилцан орлуулах мэдрэмжийг илэрхийлнэ. u_t нь тэгшитгэлийн бодит болон онолын утгын зөрүүг харуулна. Өөрөөр хэлбэл бидэнд дээрх харьцаануудаар хугацааны цуваа үүсгэх боломжтой байхад харилцан орлуулах мэдрэмжийг тоцох боломжтой гэсэн үг.

Гаалийн татварыг өөрчлөхөд гаалийн үнэ P_m нь P'_m болж өөрчлөгдөнө. Харин гаалийн үнийг өөрчлөхөд түүнийг импортлох хэмжээ нь ΔQ_m хэмжээгээр өөрчлөгдөж Q'_m болно гэж үзье. Тэгвэл 12-р тэнцэтгэл дээрээс Q'_m болон Q_m -ийг олж, тэдгээрийн харьцаанаас гаалийн тарифыг өөрчилсний дараахь импортын хэмжээг тодорхойлбол:

$$Q'_m = \left(\frac{P'_m}{P_m} \right)^\sigma Q_m \quad [15]$$

Импортын барааны үнийг P_m гэвэл тэр нь тухай бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрээс худалдан авсан үнэ P_w -г валютын тухайн үеийн ханшаар үржүүлэн үндэсний валютад хөрвүүлж, үүн дээр гаалийн татвар t_0 -ыг нэмсэн үнийн дүнгээс нэмэгдсэн өртгийн татвар v -ыг суутган авсантай тэнцүү байна гэж үзье. Тэгвэл үүнийг дараахь байдлаар илэрхийлж болно:

$$P_m = P_w * ER * (1 + t_0)(1+v) \quad [16]$$

Хэрэв гаалийн татварын хувь хэмжээг t_0 -оос t_1 болгон өөрчилбөл импортын үнэ P_m нь P'_m болж өөрчлөгдөнө.

$$P'_m = P_w * ER * (1 + t_1)(1+v) \quad [17]$$

Хэрэв тэнцэтгэл 15-д дээрх орлуулгыг оруулбал дараахь хэлбэрт шилжинэ.

$$Q'_m = \left(\frac{1+t_1}{1+t_0} \right)^\sigma Q_m \quad [18]$$

Тодорхой барааны гаалийн тарифын түвшинг t_0 -оос t_1 болгон өөрчлөхөд түүнийг импортлох тоо хэмжээ нь ΔQ_m нэгжээр өөрчлөгдөнө. Тэгвэл үүнийг 19-р тэнцэтгэлээр илэрхийлж болох бөгөөд Q_m нь тарифын түвшин байх үеийн, Q'_m нь тарифын түвшинг t_1 болгон өөрчилсний дараахь үед тухайн бүтээгдэхүүнийг импортлох тоо хэмжээг илэрхийлнэ.

$$Q'_m = Q_m + \Delta Q_m \quad [19]$$

Эндээс импортын тарифын түвшинг t_0 -оос болгон өөрчлөхөд түүнийг импортлох тоо хэмжээнд гарах өөрчлөлт -г тооцвол энэ нь дараахь томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$\Delta Q_m = Q_m \left(\left(\frac{1+t_1}{1+t_0} \right)^\sigma - 1 \right) \quad [20]$$

Дээрх томъёоноос үзвэл, дотоодын болон импортын барааны харилцан орлох мэдрэмжийг тооцож чадсан нөхцөлд гаалийн тарифыг хэдэн хувь өөрчлөөд түүнийг импортлох тоо хэмжээг хэрхэн өөрчилж болохыг урьдчилан тооцоолох боломжтой байна.

Хэрвээ дотоодын сүүт импортын сүүгээр орлуулах боломжтой бөгөөд тэдгээрийн бие биенийгээ харилцан орлох мэдрэмж нь 1, импортын тариф 5% байна гэж төсөөлье. Ийм нөхцөлд дотоодын үйлдвэрлэлийг импортын өрсөлдөөнөөс бүрэн хамгаалах хэмжээний тариф тогтооно гэж үзвэл тооцоолыг дараахь байдлаар хийнэ. Бидний тооцоолох жишээн дээр импортын тоо хэмжээ Q_m байсан гэж үзвэл бид дотоодын үйлдвэрлэлийг импортын өрсөлдөөнөөс бүрэн хамгаалахын тулд импортын тоо хэмжээг мөн Q_m хэмжээгээр бууруулах шаардлагатай гэсэн үг. Өөрөөр хэлбэл, бидний жишээн дээр $\Delta Q_m = Q_m$ байна гэсэн үг. 20-р томъёоноос дотоодын үйлдвэрлэлийг импортоос бүрэн хамгаалахад шаардлагатай тарифын түвшинг t_1 гэж үзээд тооцвол:

$$t_1 = \left(1 + \frac{\Delta Q_m}{Q_m} \right)^{1/\sigma} (1 + t_0) - 1 \quad \text{байна.} \quad [21]$$

Томъёонд орлуулга хийн шинэчлэн тогтоох тарифын түвшинг тооцвол $t_1=1.1$ гарна. Өөрөөр хэлбэл 110%-ийн гаалийн тариф тогтоож байж сая дотоодын үйлдвэрлэлийг импортоос бүрэн хамгаалах боломжтой байна.

Практикт гардаг хамгийн бэрхшээлтэй асуудал нь тодорхой бараа бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор импортын тарифыг нэмэгдүүлэхэд тухайн барааны импорт буурах боловч түүнийг үйлдвэрлэхэд зарцуулдаг бүрдэл хэсгүүдийн, эсвэл тухайн барааг ашиглан үйлдвэрлэдэг бусад барааны импорт өсөх хандлага ажиглагддаг. Жишээ нь дотоодын

сүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор импортын шингэн сүүний тарифыг нэмэгдүүлэхэд шингэн сүүг үйлдвэрлэхэд ашиглагддаг хуурай сүү, шингэн сүгээр үйлдвэрлэдэг тараг, иогурт, зайрмаг зэрэг бүтээгдэхүүний импорт өсдөг гэсэн үг.

Иймд тодорхой бүтээгдэхүүний импортын тарифыг өөрчлөхдөө түүнтэй холбоотой бусад бүтээгдэхүүний тарифыг харилцан уялдаатай байдлаар өөрчлөх нь чухал байдаг. Ингэж өөрчлөхдөө дараахь томъёог ашиглана. Үүнд:

$$t_e = \frac{t_n - A \cdot t_m}{1 - A} \quad [22]$$

t_e - импортын барааны гаалийн оновчтой тарифын түвшин

t_n - импортын барааны гаалийн нэрлэсэн татварын түвшин

t_m - тухайн импортын барааг үйлдвэрлэхэд ашигладаг импортын орцын гаалийн татварын түвшин

A - тухайн импортын барааны үнийн дүнд импортын орцын эзлэх хувийн жин

Дээр өгүүлсэн зайрмагийн гаалийн татвар 5%, шингэн сүүний импортын гаалийн татвар 10%, зайрмагны өртөгт шингэн сүүний эзлэх хувь 20% байна гэж үзээд эндээс шингэн сүүний импортын гаалийн татвартай уялдаатайгаар зайрмагны гаалийн татварын оновчтой хэмжээг тооцоолъё. $t_n=0.05$; $t_m=0.1$; $A=0.2$ байна гэж үзээд импортын тарифын оновчтой хувь хэмжээг тооцоолбол $t_e=0.0375$ буюу 3.75 хувь байна.

Зайрмаг үйлдвэрлэхэд зөвхөн сүүг гаднаас импортлож орц болгон ашигладаг бол гаалийн татварыг 3.75%-иас өндөр түвшинд тогтоовол зайрмагны оронд шингэн сүү импортлож зайрмаг үйлдвэрлэх нь илүү ашигтай бизнес байна. Харин зайрмагны гаалийн татварыг 3.75%-иас бага хэмжээнд тогтоовол зайрмаг импортлож зарах нь илүү ашигтай бизнес байх юм. Гаалийн тарифыг тогтоохдоо иймэрхүү харилцан хамаарлыг харгалзан үзэх нь бизнесийн байгууллагуудын зүгээс барааг импортлох сонголт, Түүнчилэн дотоодод үйлдвэрлэл хөгжүүлэх боломж зэрэгт шууд нөлөөлж байдаг тул энэ асуудалд судалгаа шинжилгээний үндсэн дээр нухацтай хандах нь чухал байдаг.

Шингэн ба хуурай сүүний импортын гаалийн тарифыг оновчтой тогтоох тухай

Сүү, сүүн бүтээгдэхүүн нь хүн амын хүнсний хэрэглээнд чухал байр суурийг эзэлдэг бөгөөд хуурай болон шингэн сүүг үйлдвэрийн болон гар аргаар боловсруулж, тараг, бяслаг, аарц, цэцгий, цэцгийн тос, зайрмаг гэх мэт 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Сүү, нь хүний хоол хүнсэн дэх кальцын хэрэгцээг хангаж байдаг тул ялангуяа кальцийн хэрэглээ ихтэй хүн амын зорилтот бүлгүүд болох ахмад насныхан болон бага насныхны хувьд онцгой чухал бүтээгдэхүүн юм. Гэвч эдгээр бүлгүүд орлогын хувьд хүн амын хамгийн эмзэг бүлгүүд байдаг тул сүүний үнийн асуудалд нэлээд болгоомжтой байдлаар хандах ёстой.

Экспортын орлого нь хэлбэлзэл ихтэй, төлбөрийн тэнцэл нь гол төлөв алдагдалтай гардаг, олон улсын зам тээврийн гол сүлжээнээс алслагдсан байршилтай, тээврийн өндөр өртөг зардал бүхий Монгол шиг орныг импортын сүү, сүүн бүтээгдэхүүнээр тогтвортой хангах арга зам нь дотоодод хуурай сүү болон бусад сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдал юм. Нөгөө талаас дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь зах зээлээс алслагдсан олон мянган малчдыг зах зээлтэй холбох, орон нутгийн үйлдвэрлэлийн нөөц боломжуудыг дайчлан ашиглах нөхцлийг бүрдүүлж, хөдөөгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хот хөдөөгийн хөгжлийн зааг ялгааг бууруулах зэрэг хөгжлийн томоохон асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах уу, импортын бүтээгдэхүүнээр хангах уу гэдэг нь импортын тарифыг ямар түвшинд хэмжээнд тогтоохоос ихээхэн хамааралтай. Мэдээж хэрэг сүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхгүйгээр импортын тарифыг шууд нэмэгдүүлэх нь энэ төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтэд муугаар нөлөөлөх магадлалтай. Ялангуяа өвлийн улиралд сүүний дотоодын нийлүүлэлт үндсэндээ тасардаг тул сүү, сүүн бүтээгдэхүүнд улирлын шинжтэй тарифыг мөрдөх шаардлагатай байж болох юм. Улирлын шинжтэй бус, өндөр тариф тогтоох бол дотоодод хуурай сүү үйлдвэрлэх үйлдвэрүүдээ барьж байгуулсны дараа тарифыг өөрчлөх шаардлагатай. Тэгээгүй нөхцөлд сүүний өндөр тариф нь хүн амын хамгийн эмзэг бүлгүүдийн амьжиргаанд муугаар нөлөөлөх магадлалтай юм.

Сүүний импортын тарифын оновчтой түвшинг тогтоохын тулд 1999-2018 гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэлд тулгуурлан дээрх аргачлалын дагуу дотоодын ба импортын сүүний харилцан орлох мэдрэмжийг тооцоолов. Уг тооцоогоор дотоодын болон импортын сүүний харилцан орлох мэдрэмж нь 1.02 гарч байна.

Эндээс дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах оновчтой тарифын түвшинг тооцоолбол:

$$t_1 = \left(1 + \frac{\Delta Q_m}{Q_m}\right)^{\frac{1}{\sigma}} (1 + t_0) - 1 = 1.368 \text{ буюу } 136.8\% \text{ байна.}$$

Өөрөөр хэлбэл, хуурай сүүний гаалийн татварыг ийм өндөр хэмжээнд тогтоож байж дотоодын үйлдвэрлэлийг импортын өрсөлдөөнөөс бүрэн

хэмжээгээр хамгаалах боломжтой юм. Түүнчилэн хуурай сүүний тарифыг тогтоосны дараа зайрмаг, иогурт, бяслаг гэх мэт бусад сүүгээр үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний тарифыг шинэчилсэн гаалийн татвартай уялдаатайгаар өөрчлөх хэрэгтэй. Ийм арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй нөхцөлд хуурай сүүний оронд дээр дурдсан бүтээгдэхүүнийг импортлох магадлалтай юм. Эдгээр бүтээгдэхүүнд тогтоох импортын тарифыг 21-р томьёогоор тооцно.

Дүгнэлт

Өрсөлдөөн глобаль шинжтэй болж буй өнөө үед үндэсний үйлдвэрлэлийг хамгаалан хөгжүүлэхэд гаалийн тариф чухал үүрэгтэй. Урьд өмнө улсын төсвийг бүрдүүлэхэд гаалийн тариф чухал үүрэгтэй байсан бол тариф буурахын хэрээр энэ үүрэг нь улам бүр хумигдах шинжтэй болж байна. Харин эсрэгээр үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах үүргүүд нь илүү чухал болоод байгаа юм.

Жижиг эдийн засагтай орнуудын хувьд үйлдвэрлэлийн бүхий л салбарыг нэгэн зэрэг хөгжүүлэх боломж хязгаарлагдмал тул цөөхөн хэдэн салбараа худалдааны бодлогын арга хэрэгслүүдээр хамгаалан хөгжүүлэх асуудал манай орны хувьд чухал ач холбогдолтой. Үүнд гаалийн тарифыг оновчтой тогтоох нь онцгой үүрэгтэй болно.

Монгол улс өнөөг хүртэл мөрдөж ирсэн гаалийн тарифыг тогтоохдоо шинжлэх ухааны тодорхой арга аргачлалтай болж чадаагүй юм. Энэхүү судалгааны ажлын хүрээнд гаалийн тарифын оновчтой хувь хэмжээг тогтоох аргазүйн асуудлыг хөндөж судлан, оновчтой тарифыг тооцох аргачлалыг боловсрууллаа.

Дотоодын зах зээл дэх сүүний нийлүүлэлт

Он	Үйлдвэрлэсэн (саасан) сүү, сая.л	Улаанбаатар хот дахь шингэн сүүний үнэ, л	Импортлосон хуурай сүү, тн	Импортын 1 тн хуурай сүүний үнэ ам.доллараар
1999	467.0	440	550.3	992
2000	375.6	459	707.7	802
2001	290.3	525	1662.6	1296
2002	276.6	467	1426.0	748
2003	292.4	482	1714.7	842
2004	406.3	468	1092.7	1240
2005	425.9	488	1293.1	1499
2006	450.4	525	1109.9	1436
2007	465.6	568	1112.8	1397

2008	457.4	843	1971.7	1624
2009	493.7	974	2380.7	2180
2010	365.8	1087	3810.3	3008
2011	529.9	1040	5162.7	3144
2012	588.0	1095	6243.0	3157
2013	667.0	1140	6340.1	3066
2014	765.4	1375	5784.1	3730
2015	874.4	1283	4652.9	2053
2016	891.5	1280	3640.3	2102
2017	919.5	1482	5385.4	2499

Ашигласан материал

- [1] Bergsten, C.F. and W.R. Cline (1985), “*The United States-Japan economic problems*”, Policy Analyses
- [2] Kim J. Ruhl., 2003. “*Solving the Elasticity Puzzle in International Economics*”. Job Market Paper. University of Minnesota and Federal Reserve Bank of Minneapolis
- [3] Isin Tellioglu, Kenneth W. Bailey, David Blanford., “Implicit Tariffs on Imported Dairy Product Components in the United States”. 2007.
- [4] Thomas Osang, Alfredo Pereira. 1996. “Import tariffs and growth in a small open economy”. *Journal of Public Economics* 60 (1996) 45-71.
- [5] William R. Cline & John Williamson, 2008. “*New Estimates of Fundamental Equilibrium Exchange Rates*”. Policy Briefs PB08-7, Peterson Institute for International Economics.
- [6] Warner Max Corden. 1966. “*The Structure of a Tariff System and The Effective Protective Rate*”. *Journal of Political Economy*. Vol 74. 1966/6/1, p 221-237
- [7] Warner Max Corden. “*Booming sector and de-industrialization in a small open economy*” *The economic journal*. Vol 92. 1982/12/1. p825-848
- [8] William Cline, et.al., *Trade Negotiations in the Tokyo Round: A Quantitative Assessment*, Washington, D.C., Brookings Institution, 1978.
- [9] Гаалийн Ерөнхий Газар. 2000-2019 он. “Гадаад худалдааны барааны статистик 1999-2018”. Улаанбаатар
- [10] Үндэсний Статистикийн Хороо. 2000-2019 он. “Монгол улсын статистикийн эмхэтгэл” 1999-2018. Улаанбаатар
- [11] ХХАХҮЯ, 2010. “Сүү боловсруулах үйлдвэр”-ийн техник-эдийн засгийн үндэслэл, Бизнесийн судалгааны “ММСГ” ХХК болон МУИС-ийн хамтарсан судалгааны баг, Улаанбаатар, Төслийн тайлан.